



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 20

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 6 дугаар зүйлийн 6.2.3, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын есдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Төв халхын дуулалт жүжгийн театрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 1,810,000 /нэг сая найман зуун арван мянга/ төгрөгийн балансын үнэтэй, 1,113,999.88 /нэг сая нэг зуун арван гурван мянга есөн зуун ерэн есөн төгрөг наян найман мөнгө/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй дунд хуур, морин хийлийг акталж, хавсралтын дагуу худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Төв халхын дуулалт жүжгийн театрын дарга (Д.Доржсүрэн)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг худалдаж, худалдсанаас орох орлогоор 3 ширхэг концертын морин хуур худалдан авч үндсэн хөрөнгөд бүртгэх;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 5 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.


Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



СОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны
өдрийн тогтоолын хавсралт



Төв халхын дуулалт жүжгийн театрийн актлах хөрөнгийн мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо ширхэг	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Дунд хуур	2018.12.31	1	1,050,000	240,000	810,000
2	Морин хийл /Виолончелл/	2018.12.31	1	760,000	456,000.12	303,999.88
	Хөрөнгийн нийт дүн			1,810,000 /нэг сая найман зуун арван мянга/ төгрөг	696,000.12 /зургаан зуун ерэн зургаан мянга арван хоёр мөнгө/ төгрөг	1,113,999.88 /нэг сая нэг зуун арван гурван мянга есөн зуун ерэн есөн төгрөг наян найман мөнгө/ төгрөг



**ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

48090 Мандалговь, Сайнцагаан сум

Утас: 70593232, 70593399

e-mail: umch@dundgovi.gov.mn

2022. 04. 15

№

82

танай

-ны №

-т

**ТӨВ ХАЛХЫН ДУУЛАЛТ ЖҮЖГИЙН
ТЕАТРЫН ДАРГА Д.ДОРЖСҮРЭН ТАНАА**

Танай ирүүлсэн хүсэлтийн дагуу Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай аймгийн ИТХ-ын 2022 оны 20 дугаар тогтоол гарсан тул тогтоолын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг 2022 оны 05 дугаар сард багтаан ирүүлнэ үү.

Хавсралт... хуудас

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.БАНТУЛГА

